



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 1/317

Алтай хот

Хурдан морины уралдаан зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1."Алтайн хавар 2022" хурдан морьдын уралдааныг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсугай.

2.Хурдан морины унаач хүүхдүүдэд стандартын шаардлага хангасан хувцас хэрэгсэл өмсгөх, түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авах, эрүүл мэндийн үзлэг, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамруулах шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлж, олон нийтийн хэв журмыг сахиулж хяналт тавин тайлагнаж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Б.Алтайбаатар), Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), "Алтайн Түмэн Эх" уяачдын холбоо (Р.Лхагвадорж)-нд тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ